

# ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ 4-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ, ТОДРУУЛГА.

2020.12.31

Сайнцагаан сум

Энэхүү Санхүүгийн тайлангаар Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2020 оны 03-р улирлын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Санхүүгийн тайлагналын хугацаа нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2020 оны 12-р сарын 31-аар дуусгавар болсон.

## **Нэг. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий бодлогын талаар**

### **1.Толилуулгын сүүр**

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Цагдаагийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэлээ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурийг хэрэглэсэн болно.

### **2.Төсвийн үйл явц**

Монгол Улсын Засгийн газар төсвийн гүйцэтгэлийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг ашиглан гаргадаг. Төсвийн шууд захирагчийн тайлант жилийн төсөв, түүний зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд бүрэн тусгасан.

Тэмдэглэл-1, 2 болон тайлангийн хавсралт ЦБСТ-8 маягтаар төсвийн талаар дэлгэрэнгүй харуулсан болно.

## **Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын талаар**

### **1. Орлого хүлээн зөвшөөрөлт:**

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого түүнтэй холбогдон худалдан авагч болон үйлчлүүлэгчтэй үүссэн тооцоог нягтлан бодох бүртгэлийн аккрузал зарчмаар бүртгэв.

Ирээдүйд үзүүлэх үйлчилгээ, нийлүүлэх бүтээгдэхүүний үнийг үйлчлүүлэгчээс урьдчилан хүлээн авсан бол бүтээгдэхүүн үйлчилгээг бодитой нийлүүлэх хүртэл орлогоор хүлээн зөвшөөрөхгүй, урьдчилж орсон орлогоор бүртгэх бодлогыг баримтлав.

Тус байгууллагад 2020 онд 4-р улиралд улсын төсвөөс 2.040.997,7 мянган төгрөг, өөрийн орлого 67.307,1 мянган төгрөг нийт 2.108.304,8 мянган төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 2.040.997,7 мянган төгрөг, өөрийн орлогоор 67.545,5 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажиллаа.

Мөнгөн гүйлгээний тайлан болон, үр дүнгийн тайлангаар бүртгэсэн орлогыг тайлангийн дэлгэрэнгүй харуулав.

### **2. Зардал :**

Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккрузал суурьт үндэслэн холбогдох зардлын дансдуудад хуримтлуулан бүртгэлээ. Аккрузал суурьт бүртгэлийн дагуу ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр хийгдсэн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэлээ.

Санхүүгийн тайланд мөнгөн гүйлгээ болон үр дүнгээр гарсан зардлуудыг харьцуулсан зардлын тайланг бэлтгэж хавсаргав.

### **3. Нэгтгэл:**

Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа цагдаагийн газар, хэлтсүүдийн хоорондын тооцооны ажил гүйлгээний давхардлын дүнг устгах бичилт хийх тул системийн дотоод тооцоогоор авсан хөрөнгө, материал, мөнгө санхүүжилтийг хоорондын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, тайланд орлогыг “Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /хөрөнгөөр, мөнгөөр, материалаар/”, зарлагыг “Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /хөрөнгөөр, мөнгөөр, материалаар/” гэсэн дансанд тус тус бүртгэсэн болно

### **4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- Төрийн сангийн нэгдсэн данс дахь тус байгууллагын улсын төсвийн 100080012001 бүртгэлийн дансанд 2020 оны 4-р улирлын байдлаар бүгд 2.119.992,9 мянган төгрөгийн орлого, үлдэгдэл 267,9 мянган төгрөгийг төвөлрүүлж нийт 2.119.992,9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100080012403 бүртгэлийн дансанд энэ онд улсын чанартай зам дагуу үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор Өмнөговь аймгийн болон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, цагдаагийн газрын цайны газрын түрээс болон даатгалын нөхөн төлбөрөөс 58.521,4 мянган төгрөгийн орлого орж, үүнээс 18.544,8 мянган төгрөгөөр гэрээ байгуулан хөрөнгө худалдан авч нийт 58.521,4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж үйл ажиллагаандаа бүрэн ашиглан 0 үлдэгдэлтэй байна. Ахмадын сангийн 100080012506 бүртгэлийн дансанд оны эхний үлдэгдэл болох 3.872,0 мянган төгрөг, жилийн эцэст Ахманд настны тухай хуульд заасны дагуу хэмнэгдсэн зардлаас 8.412,9 мянган төгрөг, байгууллагын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 4.070,0 мянган төгрөг нийт 12.482,9 мянган төгрөгийн орлого орж, сар шинэ, ахмадын баярын өдрийг тохиолдуулж ахмад настангуудад хүндэтгэл үзүүлж хүлээн авахад 7.903,9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 2020 оны жилийн эцсийн байдлаар 8.451,9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэхүү ахмадын сангийн үлдэгдэл нь байгууллагын үлдэгдэл болно.
- Улсын төсвийн харилцахаас жижиг мөнгөн сангийн бэлэн мөнгийг арилжааны Хаан банкинд байрших байгууллагын 5466206007 тоот харилцах дансаар 2020 оны байдлаар 2.480,0 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг хийгдэн дамжуулан гаргаагүй. Тэмдэглэл 3-д "Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө"-ийг дэлгэрэнгүй харуулсан болно.

### **5. Авлага**

Ажил үйлчилгээ үзүүлсэн, бараа, бэлэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан, бусдад шилжүүлсэн аливаа зүйлстэй холбоотой нэхэмжилсэн, төлөгдөх хугацаа нь дуусмагц мөнгө болж хувирах зүйлсийг авлагаар бүртгэв. 2020 оны жилийн эцсийн байдлаар авлага үүссэгүй болно.

Урьдчилж төлсөн тооцоо, зардал нь тайлант хугацаанд мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант хугацаанд зардал буюу мөнгө, бараа материал, үйлчилгээгээр хаагдах тооцоо тул УСНББОУС 1,4,9,11,23-ыг үндэслэн эдгээрийг авлага гэж зөвшөөрөөгүй ба Урьдчилгаа тооцоо дансанд бүртгэн санхүүгийн тайланд тусгасан болно.

Тэмдэглэл 4-д "Авлага"-ын тайлант улиралд хийгдсэн гүйлгээ болон үлдэгдлийг дэлгэрэнгүй харуулсан болно.

### **6. Бараа материал**

Цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад бараа материалын зүйлсийг ашигладаг. Санхүүгийн тайланд тусгагдсан бараа материал дансны эцсийн үлдэгдэл нь байгууллагын эзэмшилд бодитойгоор байгаа бүх бараа материалын зүйлсийг багтаасан.

Тус байгууллага нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгохдоо бараа материалын байнгын системийг ашигласан болно. Байнгын системийн дагуу бараа материалын орлого ба зарлагын хөдөлгөөн өртгийг тухайн ажил гүйлгээ гарсан өдөр бүр тооцоолж бүртгэлийг хөтлөв.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 184.853,1 мянган төгрөгийн материал худалдан авч, бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн. ЦЕГ болон харъяа цагдаагийн байгууллагаас 20.877,8 мянган төгрөгийн материал, орон нутгаас 1,0 сая төгрөгийн бараа материал орлогодон авч байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад үүднээс алба хаагчдын албан хэрэгцээнд зориулж 176.082,9 мянган төгрөгийн материал зарцуулж, 169.614,3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын зарцуулалтыг тооцож бүртгэлд тусгахдаа эхэлж авсныг эхэлж зарлагадах аргыг хэрэглэсэн.

Тэмдэглэл 5-д "Бараа материал"-ын тайлант онд хийгдсэн гүйлгээ болон үлдэгдлийг дэлгэрэнгүй харуулсан болно.

### **7. Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийг УСНББОУС-ын 17, Цагдаагийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.4 "Үндсэн хөрөнгийн бүртгэл" хэсэг болон тус хэсэгт Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар оруулсан нэмэлт өөрчлөлтийг мөрдөж бүртгэлийг хөтөлсөн.

Дараах хоёр шалгуурыг нэгэн зэрэг хангасан тохиолдолд үндсэн хөрөнгө, түүний өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгав. Үүнд:

(а) Тухайн хөрөнгөөс байгууллага нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж хүртэх боломжтой байх

(б) Хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой байх гэж заасны дагуу ХЗДХэргийн яамнаас "Үнэ төлбөргүй шилжүүлэн" авсан 1.354,5 мянган төгрөг, ЦЕГ-ын харъяа албадаас "Үнэ төлбөргүй шилжүүлэн" авсан 62.894,2 мянган төгрөгийн хөрөнгө, Орон нутгаас "Үнэ төлбөргүй шилжүүлэн" авсан 76.275,0 мянга нийт 140.523,7 мянган төгрөгийн хөрөнгийн хүлээн авч данс бүртгэлд тусгасан тайлангийн хавсралт ЦБСТ-2 маягтаар хөрөнгийн талаар дэлгэрэнгүй харуулсан болно.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд элэгдэл байгуулахдаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4 дүгээр бүлгийн 4.4 "Үндсэн хөрөнгийн бүртгэл" хэсэгт тусгасан "Үндсэн хөрөнгийн ангилал, элэгдэл тооцох арга, элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хувь хэмжээ"-г дагаж мөрдсөн болно.

Тэмдэглэл 6-д "Үндсэн хөрөнгө"-ийн тайлант онд элэгдлийн бүртгэлийг дэлгэрэнгүй харуулсан болно.

### **8. Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийг өртгөөр нь үнэлж бүртгэлд тусгасан. Биет бус хөрөнгийн өртөг гэдэг нь тухайн хөрөнгийг худалдан авах, бий болгох үеийн бодит үнэ цэнэ буюу төлсөн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн юм.

### **9. Өглөг**

Богино хугацаат өр төлбөрийг доорх байдлаар ангилж бүртгэсэн. Тус байгууллага 2020 оны жилийн эцсийн байдлаар өглөггүй гарсан болно

Тэмдэглэл 7-д "Өглөг"-ийн тайлант онд хийгдсэн гүйлгээ болон үлдэгдлийг дэлгэрэнгүй харуулсан болно.

### **10. Урт хугацаат өр төлбөр**

Санхүүгийн байдлын тайланд урт хугацаат өр төлбөр тайлагнаагүй болно.  
Тэмдэглэл 8. "Урт хугацаат өр төлбөр".

### **11. Гадаад валютын бодлого**

2020 оны 4-р улиралд гадаад валютаар гарсан ажил гүйлгээ байхгүй болно.

### **12. Болзошгүй өр төлбөр**

Алдагдал хүлээж болзошгүй тодорхой тохиолдол байхгүй тул тус байгууллагад 2020 оны 12 дугаар сарын 31-аар тайлагнах болзошгүй өр төлбөр байхгүй болно.

### **13. Амлалт**

Тус байгууллагад 2020 оны 12-р сарын 31-аар тайлагнах ямар нэгэн амлалт байхгүй болно.

## **Тэмдэглэл.**

### **№. 1 Орлогын гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан орлого нь дараах зүйлсээс бүрдэнэ:  
/төгрөгөөр/  
Төлөвлөгөө: Гүйцэтгэл: Зөрүү:

|   | Төлөвлөгөө:      | Гүйцэтгэл:       | Зөрүү:      |
|---|------------------|------------------|-------------|
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР            | 2,108,304,800.00 | 2,108,543,188.00 | -238,388.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 67,307,100.00    | 67,545,488.00    | -238,388.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих |                  |                  |             |
| Төсвөөс санхүүжих                         | 2,040,997,700.00 | 2,040,997,700.00 | 0.00        |

### **№. 2 Төсвийн зарлагын гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан зардлын задаргаа нь дараах зүйлсээс бүрдэнэ.

| Зардлын зүйл | Зардлын зүйл                                   | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Хэмнэлт, хэтрэлт |
|--------------|--|------------------|------------------|------------------|
| 1            | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН           | 2,108,304,800.00 | 2,108,275,270.80 | 29,529.20        |
| 2            | II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН                          | 2,108,304,800.00 | 2,108,275,270.80 | 29,529.20        |
| 3            | IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                         | 2,108,304,800.00 | 2,108,275,270.80 | 29,529.20        |
| 4            | Бараа, үйлчилгээний зардал                     | 2,104,234,800.00 | 2,104,205,270.80 | 29,529.20        |
| 5            | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 1,658,471,500.00 | 1,658,471,500.00 | 0.00             |
| 6            | Үндсэн цалин                                   | 1,076,721,200.00 | 1,076,721,200.00 | 0.00             |
| 7            | Нэмэгдэл цалин                                 | 549,400,500.00   | 549,400,500.00   | 0.00             |
| 8            | Гэрээт ажлын хөлс                              | 32,349,800.00    | 32,349,800.00    | 0.00             |
| 8            | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,262,500.00    | 41,262,500.00    | 0.00             |
| 9            | Тэтгэврийн даатгал                             |                  | 4,500,896.00     | -4,500,896.00    |
| 10           | Тэтгэмжийн даатгал                             |                  | 529,516.00       | -529,516.00      |
| 11           | ҮОМШӨ ний даатгал                              |                  | 423,615.00       | -423,615.00      |
| 12           | Ажилгүйдлийн даатгал                           |                  | 92,608.00        | -92,608.00       |
| 13           | Байгууллага төлөх ЭМД ийн хураамж              | 41,262,500.00    | 35,715,865.00    | 5,546,635.00     |
| 14           | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 198,026,900.00   | 198,026,880.00   | 20.00            |

|    |  |                |                |           |
|----|--|----------------|----------------|-----------|
| 15 | Гэрэл цахилгаан  | 22,811,500.00  | 22,811,474.00  | 26.00     |
| 16 | Түлш, халаалт  | 169,462,500.00 | 169,462,506.00 | -6.00     |
| 17 | Цэвэр, бохир ус  | 5,752,900.00   | 5,752,900.00   | 0.00      |
| 18 | Хангамж, бараа материалын зардал                         | 117,062,800.00 | 117,062,800.00 | 0.00      |
| 19 | Бичиг хэрэг  | 11,895,000.00  | 11,895,000.00  | 0.00      |
| 20 | Тээвэр (шатахуун)  | 91,547,800.00  | 91,547,800.00  | 0.00      |
| 21 | Шуудан холбоо  | 9,040,000.00   | 9,040,000.00   | 0.00      |
| 22 | Ном, хэвлэл  | 120,000.00     | 120,000.00     | 0.00      |
| 23 | Хог хягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00     | 660,000.00     | 0.00      |
| 24 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс           | 3,800,000.00   | 3,800,000.00   | 0.00      |
| 25 | Нормативт зардал   | 20,225,000.00  | 20,225,000.00  | 0.00      |
| 26 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 300,000.00     | 300,000.00     | 0.00      |
| 27 | Хоол, хүнс   | 18,425,000.00  | 18,425,000.00  | 0.00      |
| 28 | Нормын хувцас зөөлөн эдлэл                               | 1,500,000.00   | 1,500,000.00   | 0.00      |
| 29 | Эд хогшил худалдан авах                                  | 38,070,000.00  | 38,070,000.00  | 0.00      |
| 30 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл                             | 4,000,000.00   | 4,000,000.00   | 0.00      |
| 31 | Урсгал засвар  | 34,070,000.00  | 34,070,000.00  | 0.00      |
| 32 | Томилолт, зочны зардал                                   | 8,198,000.00   | 8,198,000.00   | 0.00      |
| 33 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр          | 20,918,100.00  | 20,888,590.80  | 29,509.20 |
| 34 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,602,700.00  | 16,585,858.00  | 16,842.00 |
| 35 | Тээврийн хэрэгслийн татвар                               | 1,013,600.00   | 1,000,993.80   | 12,606.20 |
| 36 | Тээврийн хэрэгслийн оношилгоо                            | 450,000.00     | 450,000.00     | 0.00      |
| 37 | Газрын төлбөр  | 2,851,800.00   | 2,851,739.00   | 0.00      |
| 38 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00      |
| 39 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                        | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00      |
| 40 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 4,070,000.00   | 4,070,000.00   | 0.00      |
| 41 | Бусад урсгал шилжүүлэг                                   | 4,070,000.00   | 4,070,000.00   | 0.00      |
| 42 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал           | 500,000.00     | 500,000.00     | 0.00      |
| 43 | Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал                         | 3,570,000.00   | 3,570,000.00   | 0.00      |

### №. 3 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг Санхүүгийн байдлын тайланд харуулсан ба энэ нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

/ төгрөгөөр/

|  | Өмнөх он | Тайлант он |
|--|----------|------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нийт дүн |          |            |

**№.4 Авлага**

Санхүүгийн байдлын тайланд тусгасан авлага нь дараах зүйлсээс бүрдэнэ:

/ төгрөгөөр/

|    | Авлага                           | ЭХНИЙ<br>ҮЛДЭГДЭ<br>Л | НЭМЭГДСЭ<br>Н | ХАСАГДСА<br>Н | ЭЦСИЙН<br>ҮЛДЭГДЭЛ |
|----|----------------------------------|-----------------------|---------------|---------------|--------------------|
| 2  | Ажилчидтай холбогдсон<br>авлага  | 0.00                  | 0.00          | 0.00          | 0.00               |
| 3  | Төлбөртэй үйлчилгээний<br>авлага |                       | 10,311,150.00 | 10,311,150.00 | 0.00               |
| 7  | Бусад авлага                     | 0.00                  | 24,696.00     | 24,696.00     | 0.00               |
| 19 | Орон сууцны авлага               |                       |               |               | -                  |
| 20 | Татаас санхүүжилтын<br>авлага    | 0.00                  |               |               | -                  |
| 21 | Байгууллагаас авах<br>авлага     |                       |               |               | -                  |
| 23 | Хувь хүмүүсээс авах<br>авлага    | 0.00                  | 2,323,736.00  | 2,323,736.00  | -                  |
| 25 | ДҮН                              | 0.00                  | 12,659,582.00 | 12,659,582.00 | 0.00               |



|    |                                  |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
|----|----------------------------------|----------------|--------------|--------------|---------------|---------------|--|--------------|--|--|--------------|----------------|--|
| 23 | Төсөвт байгууллагад              |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 24 | Бусад байгууллагад               |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 25 | Шилжүүлсэн /бүтцийн өөрчлөлтөөр/ |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 26 | БУСАД                            |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 27 | Акталж, устгасан                 |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 28 | Тооллогоор дутагдсан             |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 29 | Үнийн зөрүү                      |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 30 | Бусад                            |                |              |              |               |               |  |              |  |  |              |                |  |
| 31 | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ                  | 114,623,041.00 | 1,661,519.60 | 1,276,300.00 | 14,603,999.00 | 33,999,956.18 |  | 2,026,451.40 |  |  | 1,423,054.00 | 169,614,321.20 |  |

## №. 6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн байдлын тайланд элэгдлийг хассан цэвэр дүнгээр харуулна. Үндсэн хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдэнэ:

| д/д | ҮЗҮҮЛЭЛТ                              | Барилга байгууламж | Авто тээврийн хэрэгсэл | Тоног төхөөрөмж | Тавилга хэрэгсэл | Батлан хамгаалах тоног төхөөрөмж | Програ хангамж | Бусад биет бус хөрөнгө | НИЙТ ДҮН         |
|-----|---------------------------------------|--------------------|------------------------|-----------------|------------------|----------------------------------|----------------|------------------------|------------------|
| 1   | ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ДАНС                 | 39201              | 39203                  | 39205           | 39207            | 39211                            | 39301          |                        |                  |
| 2   | ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ                    | 3,964,651,332.61   | 276,229,035.04         | 355,614,039.57  | 96,300,360.00    | 49,900,200.00                    | 360,000.00     | 369,972,000.00         | 5,113,026,967.22 |
| 3   | НЭМЭГДСЭН                             |                    | 121,500,249.96         | 37,568,337.82   |                  |                                  |                |                        | 159,068,587.78   |
| 4   | Худалдан авсан, бэлтгэсэн             |                    |                        | 18,544,800      |                  |                                  |                |                        | 18,544,800       |
| 5   | Төсвийн хөрөнгөөр                     |                    |                        | 18,544,800      |                  |                                  |                |                        | 18,544,800       |
| 6   | Өөрийн хөрөнгөөр                      |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 7   | Бусад 1                               |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 8   | Хандиваар авсан                       |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 9   | Гадаадын зээл, тусламжаар             |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 10  | ЗГ-ын нөөц, хуваарилагдаагүй зардлаас |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 11  | ААН                                   |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 12  | Олон нийтийн байгууллагаас            |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 13  | Бусад эх үүсвэрээс                    |                    |                        |                 |                  |                                  |                |                        | 0.00             |
| 14  | Шилжүүлэн авсан                       |                    | 121,500,249.96         | 19,023,537.82   |                  |                                  |                |                        | 140,523,787.78   |





|    |   |                  |                |                |               |               |            |                |                  |
|----|---|------------------|----------------|----------------|---------------|---------------|------------|----------------|------------------|
| 43 | Дахин үнэлгээгээр буурсан               |                  |                |                |               |               |            |                | 0.00             |
| 44 | Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл | 167,870,545.80   | 207,867,024.11 | 162,528,854.82 | 29,070,553.27 |               | 180,000.00 |                | 567,516,987.00   |
| 45 | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ (үлдэгдэл өртөг)        | 3,796,780,786.81 | 189,862,260.89 | 230,653,522.57 | 67,229,806.73 | 49,900,200.00 | 180,000.00 | 369,972,000.00 | 4,704,578,577.00 |

**№.7 Өглөг**

Санхүүгийн байдлын тайланд тусгасан өглөгийн үлдэгдэл нь дараах зүйлсээс бүрдэнэ:

/

төгрөгөөр/

|    | ҮЗҮҮЛЭЛТ                       | ЭХНИЙ<br>ҮЛДЭГДЭЛ | НЭМЭГДСЭН        | ХАСАГДСАН        | ЭЦСИЙН<br>ҮЛДЭГДЭЛ |
|----|--------------------------------|-------------------|------------------|------------------|--------------------|
| 1  | Цалин                          | -                 | 1,654,926,630.00 | 1,654,926,630.00 | 0.00               |
| 2  | НДШ                            | -                 | 75,744,464.00    | 75,744,464.00    | 0.00               |
| 3  | ХАОАТ                          | -                 | 139,554,385.00   | 139,554,385.00   | 0.00               |
| 5  | Гэрэл цахилгааны тооцоо        | -                 | 22,322,573.00    | 22,322,573.00    | 0.00               |
| 6  | Түлш халаалтын өглөг           | -                 | 169,462,506.00   | 169,462,506.00   | 0.00               |
| 7  | Цэвэр, бохир усны өглөг        | -                 | 4,354,938.00     | 4,354,938.00     | 0.00               |
| 8  | Тээвэр шатахууны тооцоо        | -                 | 95,853,494.30    | 95,853,494.30    | 0.00               |
| 9  | Шуудан, холбооны өглөг         | -                 | 9,078,872.00     | 9,078,872.00     | 0.00               |
| 10 | Дотоод албан томилолтын тооцоо | -                 | 8,198,000.00     | 8,198,000.00     | 0.00               |
| 11 | Хоолны өглөг                   | -                 | 19,931,598.70    | 19,931,598.70    | 0.00               |
| 12 | Эмийн тооцоо                   | -                 | 294,319.60       | 294,319.60       | 0.00               |
| 13 | Урсгал засварын тооцоо         | -                 | 53,995,369.90    | 53,995,369.90    | 0.00               |
| 12 | Бусад өглөг                    | -                 | 97,503,392.20    | 97,503,392.20    | 0.00               |
| 17 | Байгууллагад төлөх өглөг       | -                 | 1,117,464,756.00 | 1,117,464,756.00 | 0.00               |
| 18 | Хувь хүмүүст төлөх өглөг       | -                 |                  |                  |                    |
| 22 | ДҮН                            | -                 | 3,468,685,298.70 | 3,468,685,298.70 | 0.00               |

**№. 8 Урт хугацаат өр төлбөр**

Санхүүгийн байдлын тайланд урт хугацаат өр төлбөр тайлагнаагүй.

**№. 9 Болзошгүй байдал**

Алдагдал хүлээж болзошгүй тодорхой тохиолдол байхгүй тул болзошгүй өр төлбөр бүртгээгүй болно.

**№. 10 Амлалт**

Тус байгууллагад 2020 оны 12-р сарын 31-аар тайлагнах ямар нэгэн амлалт байхгүй болно.

**№11. Холбоотой талууд**

Гол удирдах албан тушаалтнуудын талаархи нэгдсэн мэдээлэл нь:

|                              | Тайлант он    |
|------------------------------|---------------|
| Удирдах албан тушаалтны тоо  | 2             |
| Нийт цалин/хөлс              | 1,654,926,630 |
| Бусад нэмэгдлүүдийн нийт дүн | 834,914,276   |

## №12 Ажилчдын орон тоо, цалингийн тайлан

№12 Ажилчдын орон тоо, цалингийн тайлан

/төгрөгөөр/

| № | Албан тушаал         | Төлөвлөгөө |               |              | Гүйцэтгэл |               |              |
|---|----------------------|------------|---------------|--------------|-----------|---------------|--------------|
|   |                      | Орон тоо   | Нийт цалин    | Дундаж цалин | Орон тоо  | Нийт цалин    | Дундаж цалин |
|   | 1                    | 2          | 3             | 4=3/2        | 5         | 6             | 7=6/5        |
| 1 | Удирдах ажилтан      | 2          | 63,565,850    | 31,782,925   | 2         | 63,565,850    | 31,782,925   |
| 2 | Гүйцэтгэх ажилтан    | 107        | 1,560,129,409 | 14,580,649   | 106       | 1,552,560,092 | 14,646,793   |
| 3 | Үйлчилгээний ажилтан | 5          | 38,800,688    | 7,760,138    | 5         | 38,800,688    | 7,760,138    |
|   | Дүн                  | 114        | 1,662,495,947 | 14,583,298   | 113       | 1,654,926,630 | 14,645,368   |

ТЭМДЭГЛЭЛ, ТОДРУУЛГЫГ БИЧСЭН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ



Ц.НАРАНТОГОС